

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк /цаашид “ХОТБанк” гэх/-ны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.3 дах хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсгийг үндэслэн Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хорооноос ХОТБанк байгуулах зөвшөөрлийг олгох нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ХОТБанк нь хаалттай хувьцаат компани, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байх бөгөөд үүсгэн байгуулагч нь Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эсхүл гадаадын банк, санхүүгийн байгууллага байна.
- 1.3. ХОТБанк байгуулах тухай Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол ХОТБанк байгуулах зөвшөөрлийг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.5-д заасан банкны үйл ажиллагааны зөвшөөрлийн хамт олгож болно.
- 1.4. Энэ журмын 1.3-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах хорооноос олгоно.
- 1.5. Монголбанк нь ХОТБанкны тухай хууль тогтоомжийг үндэслэн ХОТБанк байгуулах өргөдлийг энэ журмын дагуу хянаж, шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас газар дээр нь очиж баталгаажуулж болно.
- 1.6. Монголбанк ХОТБанкны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэл тогтоогдвол энэ тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
- 1.7. Монголбанк нь ХОТБанкны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдвол банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНК БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

- 2.1. ХОТБанк үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлийн хуулийн этгээд нь Банкны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, 23.1-д заасан шаардлагыг хангасан байна.

- 2.2. ХОТБанк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь ХОТБанкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 заасан дараах шаардлагыг хангасан байна.
- 2.3. ХОТБанкны удирдлага нь Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

ГУРАВ. ХОТБАНК БАЙГУУЛАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- 3.1. ХОТБанк үүсгэн байгуулагч нь банк байгуулахад шаардагдах баримт бичгийг дараах бүрдүүлбэрийн дагуу бэлтгэж, товъёог үйлдэн албан бичгээр Монголбанканд ирүүлнэ:
 - 3.1.1. Энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаргасан “ХОТБанк байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл”;
 - 3.1.2. Өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон итгэмжлэл, түүнтэй адилтгах шийдвэр, тогтоол;
 - 3.1.3. ХОТБанк үүсгэн байгуулах шийдвэр;
 - 3.1.4. Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас;
 - 3.1.5. Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд нийцүүлэн зохион байгуулсан “Үүсгэн байгуулагчдын хурал”-ын тогтоол, тэмдэглэлийн хамт;
 - 3.1.6. ХОТБанк-ны дүрэм;
 - 3.1.7. ХОТБанк-ны удирдлага зохион байгуулалтын бүтэц;
 - 3.1.8. ХОТБанк-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д тавигдсан шаардлагыг хангасан ТУЗ-ийн гишүүдийг сонгосон шийдвэр, ТУЗ-ийн гишүүн тус бүрээр энэ журмын 2 дугаар хавсралтад заасан “ХОТБанкны эрх бүхий албан тушаалтан этгээдийн тодорхойлолт”;
 - 3.1.9. Үүсгэн байгуулагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримтын хамт;
 - 3.1.10. ХОТБанкны тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан эрхлэх үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан “ХОТБанк байгуулах эдийн засгийн үндэслэл, бизнес төлөвлөгөө”;
 - 3.1.11. Энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу банкны техник, тоног төхөөрөмж программ хангамж, ажлын байрны тодорхойлолт;
 - 3.1.12. Үүсгэн байгуулагдах ХОТБанк нь гадаад улсын банк, санхүүгийн байгууллага бол ХОТБанкны хуулийн 17.2-д заасан шийдвэр;

- 3.2. Энэ журмын 3.1.6-д заасан дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, ХОТБанкны тухай хуульд заасан үйл ажиллагаа, хязгаарлалт, хэм хэмжээнд нийцтэй байна.
- 3.3. Төлөөлөн удирдах удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон этгээд нь ХОТБанкны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шалгуурыг хангаж байгааг шалган баталгаажуулсан үүсгэн байгуулагчид (хувьцаа эзэмшигчид)-ын хурлын дарга, хурал зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга (цаашид Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга)-ын гарын үсгээр баталгаажсан тодорхойлолт
- 3.4. Банк байгуулахтай холбоотой тогтоол, шийдвэр, төрийн захиргааны байгууллагаас гаргасан албан тоот тодорхойлолтыг эх хувиар нь холбогдох баримт, нотолгооны нотариатаар баталгаажуулсан хуулбар эсхүл төрийн цахим үйлчилгээний системээс дахин давтагдашгүй кодоор цахимаар баталгаажих боломжтой байх шаардлагыг хангасан байна.
- 3.5. Банк байгуулахтай холбоотой баримт бичиг, нотлох баримт нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол эх хувийг нотариатаар баталгаажуулсан англи, монгол орчуулгын хамт ирүүлнэ.
- 3.6. Монголбанк нь ХОТБанк байгуулахтай холбоотой асуудлаар нэмэлт материал шаардаж болох бөгөөд шаардлагатай асуудлаар эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас тодруулга, лавлагаа авч болно.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 4.1. ХОТБанк байгуулах зөвшөөрөл авах өргөдөл гаргасантай холбоотой болон ХОТБанкны тухай хууль, энэ журмын 1.6 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгохоос татгалзсан нь зөвшөөрөл хүссэн этгээдийн гаргасан аливаа зардлыг Монголбанк хариуцах үндэслэл болохгүй.

ТӨСӨЛ
ХОТБанкны зөвшөөрлийн нөхцөл,
шаардлагыг тогтоох журмын 1 дүгээр хавсралт

..... ХОТБАНК БАЙГУУЛАХ
ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

1. БАЙГУУЛАХ ХОТБАНКНЫ НЭР					
2. БАЙГУУЛАХ ХОТБАНКНЫ ХАЯГ					
3. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)					
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (төгрөгөөр)					
Хувьцааны тоо ширхэг					
4. ХОТБАНК ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД					
	Оноосон нэр (овог, нэр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Худалдаж авсан хувьцааны тоо ширхэгээр хувиар		Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)
1					
2					
...					
<i>о Дээрх хуулийн этгээд, иргэд нь хууль ёсны үйл ажиллагааны орлогоороо тус банкныг байгуулж байгаа болно.</i>					
5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ					
	Эрхлэх албан тушаал	Овог, нэр			
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга				
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга				
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн				
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн				
.					
<i>о Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй, банкны үйл ажиллагааг шуударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршилагатай, банкны ашиг сонирхлыг хувийн ашгаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж ХОТБанк-ны тухай хууль, Банкны тухай хууль болон энэхүү журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан</i>					

<i>тушаалд томилсон болно.</i>	
6. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА	
	<u>Эрхлэх албан тушаал</u>
	<u>Овог, нэр</u>
1	
2	
<i>о Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь банкиг удирдахад харшлахгүй, банкны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршилагатай, банкны ашиг сонирхлыг хувийн ашигаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж ХОТБанкны тухай хууль, Банкны тухай хууль болон энэхүү журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.</i>	
7. ХОТБАНК БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛД ХАВСАРГАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	
1	
2	
3	
...	
Бүгд хуудас	
<i>о Дээрх баримт бичгүүдийг ХОТБанк-ны тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 202.. оны дугаар тушаалаар батлагдсан "ХОТБанкны зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох журам"-ын дагуу үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа, хуурамч мэдээлэл орсон тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.</i>	
8. ТӨЛӨӨЛӨХ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	
о Хуулийн этгээд бол	
о Иргэн бол	
Оноосон нэр (<i>иргэн бол овог нэрээ бичнэ үү</i>)	
Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Хаяг (<i>иргэн бол оршин суугаа хаягаа бичнэ үү</i>)	
Холбоо барих утас	

ХОТБанк байгуулах өргөдлийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авч, хянан шийдвэрлэж, банк байгуулах зөвшөөрлийг олгоно уу.

Хавсралт. Дугаарласан . . . хуудастай.

ХОТБАНК БАЙГУУЛАХ ӨРГӨДӨЛ ГАРГАСАН:

Хуулийн этгээдийн

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

(нэр)

ХОТБАНК үүсгэн байгуулагч нь

иргэн бол

(гарын үсэг)

(нэр)

..... ХОТБАНКНЫ
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛ				
<i>(томилогдох албан тушаалын нэрийг энд бичнэ үү)</i>				
I.Товч танилцуулга				
Ургийн овог:		цээж зураг		
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Суурин болон гар утасны дугаар:				
II.Боловсрол <i>(боловсролын гэрчилгээнуудийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана уу)</i>				
Боловсрол	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр	Улс, хотын нэр
...				
...				
...				
III.Ажил эрхлэлт				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
...				

...			
...			
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.			
д/ д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
1			
2			
...			
Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.			
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар
1			
2			
...			
IV.Гэр бүлийн байдал (<i>гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу</i>)			
	Овог, нэр, Регистрийн дугаар	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
1			
2			
...			
V.Харилцагч банк			
1			
2			
...			

Нотлох баримтуудыг хавсаргав.

Хавсралт. Дугаарласан . . . хуудастай.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны сарын-ны өдөр

..... ХОТБАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА, ГИШҮҮН, ХОТБАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ТОМИЛОГДОХ
ЭТГЭЭДИЙН АСУУЛГА

1	Та өөр улсын эрх бүхий байгууллагад зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байсан уу? Таны хүсэлтийг хүлээж аваагүй, эсвэл татгалзсан тохиолдол бий юу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?	
2	Та аль нэг улсад иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл эдэлж байсан уу (18 нас хүрэхээс өмнө үйлдэж байсан гэмт хэрэг, тээврийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой зөрчлийг хялбарчилсан журмаар шийдвэрлэсэн бол энд хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
3	Санхүүгийн байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
4	Та гишүүн байсан мэргэжлийн байгууллагын шийдвэрээр сахилгын хариуцлага хүлээж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
5	Та өмнө нь луйвар, залилан, эсвэл ижил төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй орлогын талаар мэдүүлэг өгч байсан уу (хараат бус шинжээчээр ажиллаж байсан бол хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
6	Та, эсвэл таны хувьцаа эзэмшдэг, захирал, гүйцэтгэх удирдлага, мөн/эсвэл ажилтнаар нь ажилладаг, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг байгууллага, нөхөрлөл нь төрийн, мэргэжлийн, эсвэл бусад төрлийн зохицуулагч байгууллагын зүгээс мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
7	Таныг албан тушаалаас тань огцруулж байсан, эсвэл албан тушаалд томилогдохтой холбогдуулан татгалзаж байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	

8	Таныг өөр улсад шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
9	Та өөр улсад шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болж байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
10	Та хуулийн этгээд үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэхтэй холбоотой, эсвэл хуулийн этгээдийн удирдлага, ажилтны эсрэг залилан, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусад албан тушаалын гэмт хэрэгт холбогдон аль нэг улсад иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэгдэн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
11	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, эсвэл ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл нь өр төлбөрөө бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн барагдуулж чадаагүй тохиолдол бий юу? Таныг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нэг жилийн дотор ийм тохиолдол гарсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
12	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөө цуцлуулж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
13	Та итгэлцэл, фидуци болон эдгээртэй адилтгах бусад төсөөтэй харилцааг тодорхой шалтгааны улмаас шаардсаны дагуу дуусгавар болгож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
14	Та энэ байгууллагад хэн нэгэн гуравдагч этгээдийн удирдлага, зааварчилгааны дор ажиллах/ажиллаж байна уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
15	Та холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн үү?	

Би энэ тодорхойлолтыг гаргаснаар мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд банкаараа дамжуулан эрх бүхий байгууллагад 21 хоногийн дотор мэдэгдэнэ.

Би дээрх мэдүүлгийн эсрэг баримт нотолгоо гарч ирсэн, эсхүл санаатай худал мэдүүлсэн тохиолдолд ХОТБанкны тухай хууль, Банкны тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.

Овог, нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

..... ХОТБАНКНЫ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ХОТБанк нь үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд үйл ажиллагаандаа (програм хангамжийн нэрийг бичнэ) програм хангамж ашиглаж, програм хангамж нь мэдээллийн нууцлал, найдвартай ажиллагааг хангасан болохыг баталж байна.

ХОТБанк нь үйл ажиллагаа эрхлэхэд зориулж Улаанбаатар хот (. аймаг)-ын (хаяг) орших үл хөдлөх хөрөнгийг худалдан авсан (түрээсэлсэн) (аль нь болохыг доогуур нь зурах) бөгөөд энэхүү байр нь нийт. метр квадрат талбайтай, банкны үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой бөгөөд банкны аюулгүй ажиллагааг хангах харуул хамгаалалтын. компанитай болон дохиолол хамгаалалтын компанитай гэрээ байгуулахаар урьдчилан тохиролцсон болно.

Хавсралт:

- 1.ХОТБанкны үйл ажиллагаа эрхлэх үл хөдлөх хөрөнгийг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээсэлсэн бол түрээсийн гэрээ.
- 2.ХОТБанкны програм хангамжийг нийлүүлж байгаа этгээдтэй хийсэн гэрээ, уг програм нь банк болон харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нотлох баримт, Монголбанкны банк хоорондын сүлжээ болон зээлийн мэдээллийн сантай холбогдох боломжтой байх.
- 3.Харуул хамгаалалтын болон дохиолол хяналтын компанитай гэрээ байгуулахаар урьдчилан тохирсон болохыг нотлох баримт.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

(гарын үсэг)

(нэр)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)